



ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар сарын 05

Дугаар 02/14

Жаргалант сум

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

- 1.Тус сумын “Орхон аймгийн Жаргалант сумын 500 тоннын төмс хүнсний ногооны зоорийг ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Дээрх журмын хэрэгжилтэд хяналт тавин, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг сумын Засаг дарга (Л.Учралд)-д үүрэг болгосугай.




ДАРГА

Ш.БИЛГҮҮНБААТАР

1024010065

**ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН 500 ТОННЫ
ТӨМС ХҮНСНИЙ НОГООНЫ ЗООРИЙГ АЖИЛДУУЛАХ ЖУРАМ**



Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1.Төмс хүнсний ногооны тариалан эрхэлж буй өрхийн тариаланч иргэд, бүлэг, хоршоо, аж ахуй нэгж байгууллага стандартын шаардлага хангасан нөхцөлд төмс, хүнсний ногоогоо хадгалах, тээвэрлэлт хийх, худалдааны сүлжээг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх тэдгээрийн хөдөлмөрийг хөнгөвчилж ажлын бүтээмжийг дээшлүүлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд зорилго нь оршино.

1.2 Энэхүү журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон бусад бодлогын баримт бичгийг удирдлага болгож, хууль дээдлэх, шударга ёс, ил тод байх, адил тэгш хандах зарчмыг баримтална.

1.3. Энэхүү журмаар Жаргалант сумын 500 тонны төмс хүнсний ногооны зоорийг ажиллуулах харилцааг зохицуулна.

Хоёр. Зоорийг ажиллуулах үндсэн зарчим

2.1. Зоорь, түүний техник тоног төхөөрөмж нь Засаг даргын Тамгын газрын өмч бөгөөд ашиглалтын зардлаа нөхөх хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

2.2.Зоорь ажиллуулах журам, ашиглалтын төлбөрийн хэмжээг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан мөрдөнө.

2.3.Орон нутгийн өмчит компани болон хоршоо, бусад хувийн хэвшилд гэрээгээр эзэмшүүлж болно.

2.4.Зооринд төмс, лууван, манжин, байцай болон зоорины ажиллах горимд тохирсон ногоо хадгална.

2.5.Эзэмшигч, ашиглагч нь Төмс, хүнсний ногоо хадгалах MNS 3024:2020 стандартыг хангаж ажиллана.

2.6.Зооринд ногоо хадгалахад орон нутгийн иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавина.

2.7.Зоорины хүртээмжийг жигд хангах зорилгоор 1 иргэн, аж ахуй нэгж 30 тн хүртэлх ногоог хадгална.

2.8. Зоорины хэвийн үйл ажиллагааг хангах Засаг даргын Тамгын газар удирдлага, зохион байгуулалтаар хангана.

2.9.Төмс, хүнсний ногоо хадгалах үеийн хэвийн хорогдлыг Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/43 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар тооцно.


2.10 Зоорийг эзэмшигч, ашиглагч бүтээгдэхүүн хадгалахдаа хадгалуулагч этгээдтэй хадгалалтын гэрээ болон хариуцлагын гэрээ байгуулан ажиллана.

2.11.Зоорины техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, засвар, техник үйлчилгээ, хадгалалт хамгаалалтыг эзэмшигч, ашиглагч этгээд хариуцна.

2.12.Зоорины ажиллах журмыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй хүргэж мэдээлнэ.

Гурав. Хадгалагчийн эрх, үүрэг

3.1.Зооринд хадгалах төмс, хүнсний ногоог хүлээн авахдаа ялгаж цэвэрлэж стандартад нийцүүлсэн байхыг шаардах.



- 3.2. Хадгалалтын төлбөр, хадгалалтаас үүссэн зардлыг төлөх хүртэл хадгалуулсан эд хөрөнгийг буцааж шилжүүлэхээс татгалзах.
- 3.3. Зооринд ногоо хадгалах захиалгыг зоорины нярав хүлээн авч захиалгын дагуу хаягжуулан агуулахын баримт олгоно.
- 3.4. Хадгалж байгаа төмс, хүнсний ногоог хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;
- 3.5. Хадгалагч ногоо хадгалж байх хугацаанд хорогдол үүсэх нөхцөл бүрдсэн тухай хадгалагч хадгалуулагчид талд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 3.6. Хадгалуулсан ногоог хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр түүнийг ашиглахгүй байх;
- 3.7. Хадгалж байгаа ногооны талаар гаргасан гуравдагч этгээдийн шаардлагыг хадгалуулагчид мэдэгдэх;
- 3.8. Хадгалуулсан ногооны өрөөний хадгалалтын горим галын аюулгүй байдлыг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах;
- 3.9. Хадгалуулагчийг хадгалуулсан ногоогоо үзэж, хянахын тулд хадгалсан газарт орох, ногоогоо борлуулах нөхцөлийг бүрдүүлнэ
- 3.10. Гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгалагч нь хадгалалтад шилжүүлсэн эд хөрөнгийг алдсан, тоо хэмжээг дутаасан горимын бус хорогдол гарсан тохиолдолд учирсан хохирлыг төлнө.
- 3.11. Зоорины үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор шаардлагатай төсвийг сумын төсөвт тусган асуудлыг шийдвэрлэнэ.

Дөрөв. Хадгалуулагчийн эрх, үүрэг

- 4.1 Хадгалуулагч нь журамд заасан хэмжээний төмс хүнсний ногоог уг зооринд хадгалуулах эрхтэй
- 4.2 Хадгалалтын явцад хяналт тавих эрхтэй
- 4.3 Хадгалуулагч гэрээгээр тохирсон хугацаанд төмс, хүнсний ногоо буцаан авах үед хадгалагчийн буруутай үйлдлээс хугацаа хожимдсон тохиолдолд учирсан хохирлоо төлүүлэх эрхтэй.
- 4.3 Зооринд хадгалах төмс, хүнсний ногоог хүлээлгэн өгөхдөө ангилан ялгаж хадгалалтын стандартад нийцүүлсэн байх /
- 4.4 Хадгалалтын явцад төмс хүнсний ногоо өвчилж муудсан тохиолдолд ялгаж цэвэрлэх, бусдад халдварлуулахгүй байх
- 4.5 Хадгалагчид төмс, хүнсний ногоо хадгалах явцад гарсан зайлшгүй зардлыг гэрээний дагуу төлөх
- 4.6 Төмс хүний ногооны зоорины хадгалах горим алдагдсанаас бусад тохиолдолд гарсан хохирлыг хадгалуулагч тал бүрэн хариуцна

Тав. Төлбөр тооцоо

- 5.1. Хадгалуулагч төмс, хүний ногоо хадгалуулсны төлбөрийг хадгалагчид батлагдсан үнийн дүнгээр төлнө.
- 5.2. Хадгалагчийн Төрийн банкны 100210255001 тоот дансанд шилжүүлэх эсвэл бэлнээр ЗДТГ-ын нярав төлнө.
- 5.3. Төлбөр төлөх хугацааг хожимдуулсан тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх алданги төлнө.

5.4.Эд хөрөнгийн хадгалалттай холбогдон үүссэн зардлыг төлүүдэхээр Иргэний хуулийн 429 дүгээр зүйлийн 429.17-т зааснаар хадгалагч тухайн эд хөрөнгийг барьцаалах эрхтэй.

Зургаа. Бусад

6.1.Зоорины сул зогсолтын үед ашиглалтыг сайжруулах зорилгоор төмс хүнсний ногооны хадгалалтад сөрөг нөлөөгүй бусад бүтээгдэхүүнийг зах зээлийн үнэ ханшаар хадгалж болно

6.2.Зоорины үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүрийн 12 сард багтаан сумын иргэдийн Төлөөлөгчийн Хуралд тайлагнана.

6.3.Журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг сумын иргэдийн Төлөөлөгчийн Хуралд танилцуулан өөрчлөлт оруулна.

Долоо. Хориглох заалт

7.1. Зооринд хортой болон төмс хүнсний ногооны хадгалалтад муугаар нөлөөлөх бүтээгдэхүүнийг хадгалахыг хориглоно.

Найм. Хадгалалтын хугацаа дуусгавар болох

8.1.Хадгалалтын хугацаа дуусгавар болсны дараа агуулахын баримт эзэмшигч нь эд хөрөнгийг агуулахаас гаргах арга хэмжээ авахгүй бол хадгалагч түүнд арван дөрөв хоногийн нэмэлт хугацаа олгох бөгөөд энэ хугацаанд эд хөрөнгийг буцаан авахгүй бол хадгалагч түүнийг худалдах эрхтэй. (Иргэний хуулийн 430.2 дахь заалт)

Ес. ХАРИУЦЛАГА

9.1.Энэ журмыг зөрчсөн тохиолдолд Иргэний хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХҮНСНИЙ НОГОО ХАДГАЛАХ ҮНЭ ТАРИФ

Д/Д	Хадгалах хүнсний ногооны нэр төрөл	Хэмжих нэгж	1 сар хадгалах хөлс	Нийт хадгалалтын хугацаанд / дундажаар 5 сар/
1	Төмс	1тонн	10,000	50,000
2	Лууван	1тонн	12,000	60,000
3	Манжин	1тонн	12,000	60,000
4	Байцай	1тонн	15,000	75,000

---000---